



MONGOLIA
MINISTRY OF FOREIGN AFFAIRS

Р/20 - 563

Монгол Улсын Гадаад харилцааны яам тус улсад суугаа Дипломат төлөөлөгчийн болон Олон улсын байгууллагын Суурин төлөөлөгчийн газруудад хүндэтгэлээ илэрхийлэхийн ялдамд шинэ коронавирусын халдвар (COVID-19) дэлхий даяар өндөр хурдацтайгаар тархаж байгаатай холбогдуулан Монгол Улсын онцгой комиссын 2020 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаан, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаас тус тус дараах шийдвэрийг гаргасан болохыг үүгээр мэдэгдэх завшаан тохиолдов.

1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэн хугацааг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөс 5 дугаар сарын 31-ний өдрийг дуустал сунгах,
2. Монгол, Оросын хилийн бүх боомтоор нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2020 оны 4 дүгээр сарын сарын 30-ны өдрөөс 5 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хязгаарлах,
3. Монгол, Хятадын хилийн бүх боомтоор нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2020 оны 4 дүгээр сарын сарын 30-ны өдрөөс 5 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хязгаарлах зэрэг болно.

Монгол Улсын Гадаад харилцааны яам тус улсад суугаа Дипломат төлөөлөгчийн болон Олон улсын байгууллагын Суурин төлөөлөгчийн газруудад нэн өндөр хүндэтгэлээ дахин илэрхийлж байна.

2020 оны 4 дүгээр сарын "29"-ны өдөр



ДИПЛОМАТ ТӨЛӨӨЛӨГЧИЙН
БОЛОН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН
СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРУУДАД
Улаанбаатар